



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 704

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 508 дугаар тогтоолын хавсралтаар баталсан акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалтын 487 дүгээр мөрөнд заасан “Зуунмод конторын барилга”, 559 дүгээр мөрөнд заасан “Соната-6 маркийн 07-99 УБҮ улсын дугаартай автомашин”-ыг хавсралтаас тус тус хассугай.

2. Тогтоолын хавсралтаас 2 нэр төрлийн хөрөнгө хассантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 508 дугаар тогтоолын 1 дэх заалтыг “839 нэрийн, 904,937,343.01 (есөн зуун дөрвөн сая есөн зуун гучин долоон мянга гурван зуун дөчин гурван төгрөг нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ